



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/130

Хэрлэн сум

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих  
төслийг ил тод, нээлттэй зохион байгуулах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр зарласан төсөл хөтөлбөрийг олон нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн хэлтсийн дарга
Гишүүд	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хөдөлмөр, эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслүүдийг цаг хугацаанд нь ил тод, нээлттэй зарлаж, шалгаруулахад хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

• 231010354